DEFENSE RESEARCH INSTITUTE OF MONGOLIA

Journal of Security and Defense Studies

Journal homepage:
https://mids.gov.mn/category/ayulgui_baidal-2/

ISSN: 2220-9115, E-ISSN: 2708-1230

Research Article

DOI: https://doi.org/10.65816/jsds.2026.02.004

The Women, Peace and Security Agenda: Formulating a National Action Plan

Beejin Khandsuren[1], Byamba Baatarsuren[2], Terbish Mungunshatar[3]

[1]*Ph.D., associate professor, Deputy Director, The Institute for Strategic Studies, National Security Council, Ulaanbaatar, Mongolia, E-mail address: khandsuren@iss.gov.mn ORCID: 0009-0002-0543-653*

[2]*Ph.D., Professor, Senior research fellow, Policy analysis center, Defense Research Institute of Mongolia E-mail address: baatarsuren@mids.gov.mn, ORCID: 0009-0008-3468-4144*

[3]*Research Fellow, The Institute for Strategic Studies, National Security Council, Ulaanbaatar, Mongolia E-mail address: mungunshatar@iss.gov.mn ORCID: 0009-0004-5788-7447*

Received: 10 May 2026 *Revised: 02 June 2026*
Accepted: 30 June 2026 *Published online: 28 July 2026*

CC BY

ABSTRACT

The Women, Peace and Security agenda is aimed at increasing women's participation in peace processes, conflict prevention, peacebuilding, and post-conflict reconstruction, as well as protecting women and girls from armed conflict. The agenda has evolved beyond a policy framework for promoting gender equality and is increasingly becoming an important component of security governance. The main mechanism for implementing the agenda at the national level is the National Action Plan (NAP), which serves as a key policy document for translating international commitments into national policies and strategies. In the case of Mongolia, the development of its NAP is still at an initial stage. This article examines the content of the Women, Peace and Security agenda, key issues to be considered in developing a NAP, and the experiences and lessons learned from other countries. The findings show that recent NAPs are shifting from broad, declaratory objectives toward more sophisticated policy frameworks that include specific goals, measurable indicators, implementation accountability systems, localized implementation features, financing mechanisms, monitoring and evaluation, and responses to emerging security challenges and technological changes. These experiences are significant for developing Mongolia's NAP in alignment with the country's national context, security environment, and institutional capacity.

Keywords: *Women, Peace and Security; United Nations Security Council Resolution 1325; National Action Plan; gender-responsive policy*

Эмэгтэйчүүд, энх тайван ба аюулгүй байдал хөтөлбөр: Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах нь

Бээжин Хандсүрэн[1], Бямба Баатарсүрэн[2], Тэрбиш Мөнгөншатар[3]

[1]*Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Стратеги судалгааны хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор (Ph.D), дэд профессор, khandsuren@iss.gov.mn ORCID: 0009-0002-0543-653*

[2]*Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Бодлогын дүн шинжилгээний төвийн Эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D), профессор, baatarsuren@mids.gov.mn, ORCID: 0009-0008-3468-4144*

[3]*Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Стратеги судалгааны хүрээлэнгийн шинжээч, магистр, хурандаа, mungunshatar@iss.gov.mn ORCID: 0009-0004-5788-7447*

ХУРААНГУЙ

Эмэгтэйчүүд, энх тайван ба аюулгүй байдал хөтөлбөр нь энх тайвны үйл явц, мөргөлдөөнөөс урьдчилан сэргийлэх, энхийг бэхжүүлэх болон мөргөлдөөний дараах сэргээн босголтын үйл ажиллагаанд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, зэвсэгт мөргөлдөөнөөс эмэгтэйчүүд, охидыг хамгаалахад чиглэсэн. Тус хөтөлбөр нь жендэрийн тэгш байдлыг дэмжих бодлогын хүрээнээс давж, аюулгүй байдлын засаглалын чухал бүрэлдэхүүн хэсэг болон хөгжиж байна. Хөтөлбөрийг үндэсний түвшинд хэрэгжүүлэх үндсэн механизм нь Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө (ҮҮАТ) бөгөөд энэ нь олон улсын өмнө хүлээсэн үүрэг амлалтыг үндэсний бодлого, стратегид тусгах бодлогын үндсэн баримт бичиг юм. Монгол Улсын хувьд ҮҮАТ-гөө боловсруулах ажил эхлэлийн шатанд байна. Энэхүү өгүүллээр Эмэгтэйчүүд, энх тайван, аюулгүй байдал хөтөлбөрийн агуулга, ҮҮАТ боловсруулахад анхаарах асуудлууд болон бусад улс орнуудын туршлага, сургамжийг судалсан. Судалгааны үр дүнгээс харахад сүүлийн үеийн ҮҮАТ-үүд нь өргөн хүрээтэй, тунхаглалын шинжтэй зорилгоос илүү тодорхой зорилт, хэмжигдэхүйц шалгуур үзүүлэлт, хэрэгжилтийн хариуцлагын тогтолцоо, нутагшсан хэрэгжилтийн онцлог, санхүүжилтийн механизм, хяналт-шинжилгээ, үнэлгээ, мөн шинээр үүсэж буй аюулгүй байдлын сорилт, технологийн өөрчлөлтийг тусгасан бодлогын илүү боловсронгуй хүрээ рүү шилжиж байгааг харуулж байна. Эдгээр туршлага нь Монгол Улсын ҮҮАТ-г үндэсний нөхцөл байдал, аюулгүй байдлын орчин, институцийн чадавхтай уялдуулан боловсруулахад чухал ач холбогдолтой болохыг судалгааны үр дүн онцолж байна.

Түлхүүр үг: *Эмэгтэйчүүд, энх тайван ба аюулгүй байдал, НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 1325 дугаар тогтоол, Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө, жендэрийн мэдрэмжтэй бодлого*

Нэг. Эмэгтэйчүүд, энх тайван, аюулгүй байдал хөтөлбөрийн агуулга

НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл 2000 онд 1325 дугаар тогтоолыг баталснаар “Эмэгтэйчүүд, энх тайван ба аюулгүй байдал” хөтөлбөрийг албан ёсоор эхлүүлсэн бөгөөд энэ нь олон улсын аюулгүй байдлын бодлого, засаглалын хөгжилд чухал эргэлтийн цэг болсон гэж үздэг (Nowrojee 1996). Энэхүү тогтоол нь зэвсэгт мөргөлдөөн, энхийг сахиулах ажиллагаа, мөргөлдөөний дараах сэргээн босголтын үйл явцад жендэрийн хэмжээсийг системтэйгээр тусгах шаардлагыг институцийн түвшинд баталгаажуулсан. Ингэснээр эмэгтэйчүүдийг зөвхөн хамгааллын “объект” хэмээн үзэх уламжлалт хандлагыг халж, тэднийг энх тайвны хэлэлцээ, аюулгүй байдлын шийдвэр гаргалт дахь тэгш эрхтэй оролцогч хэмээн хүлээн зөвшөөрсөн шинэ хандлагыг тогтоосон байна. НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 1325 дугаар тогтоол нь жендэрийн тэгш байдлыг хүний эрхийн асуудлаас аюулгүй байдлын бодлогын түвшинд шилжүүлсэн. Тус тогтоолыг батлагдахад тухайн үед улс төр,

эрх зүйн суурийг бүрдүүлсэн хэд хэдэн хүчин зүйлийг онцлон тэмдэглэх хэрэгтэй.

Нэгдүгээрт, Хүйтэн дайны дараах 1990-ээд оны зэвсэгт мөргөлдөөнүүд, тухайлбал Югославын задрал болон Руандагийн иргэний дайны үеэр өргөн хүрээний бэлгийн хүчирхийлэл үйлдэгдсэн нь эмэгтэйчүүдийн аюулгүй байдлын асуудлыг олон улсын анхаарлын төвд авчирсан. Эдгээр мөргөлдөөн нь бэлгийн хүчирхийллийг дайны “дагалдах үр дагавар” бус, харин айдас төрүүлэх, нийгмийн бүтцийг задлах зорилгоор зориудаар ашигласан, зарим тохиолдолд “дайны зэвсэг” болгон хэрэглэснийг харуулсан ноцтой жишээ болсон.

Хоёрдугаарт, 1995 онд болсон Дэлхийн эмэгтэйчүүдийн IV бага хурлаас баталсан Бээжингийн тунхаглал болон Үйл ажиллагааны хөтөлбөр нь зэвсэгт мөргөлдөөний нөхцөлд амьдарч буй эмэгтэйчүүдийг хамгаалах, мөн зөрчилдөөнийг шийдвэрлэх, энх тайвны хэлэлцээ, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхийг тэргүүлэх зорилтын нэг болгон тодорхойлсон (Rome statute of the International Criminal Court 2021).

Гуравдугаарт, хуучин Югослав болон Руанда дахь зэвсэгт мөргөлдөөний сургамж нь олон улсын хамтын нийгэмлэгийг бэлгийн хүчирхийллийг олон улсын гэмт хэрэг хэмээн хүлээн зөвшөөрөхөд хүргэсэн. Энэ хүрээнд 1998 онд батлагдсан Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэм нь хүчингийн хэрэг, бэлгийн боолчлол, албадан жирэмслэлт зэрэг үйлдлийг дайны гэмт хэрэг болон хүн төрөлхтний эсрэг гэмт хэргийн бүрэлдэхүүнд тооцох эрх зүйн зохицуулалтыг тусгаснаар олон улсын эрүүгийн эрх зүйн хөгжилд шинэ шат нээсэн.

Дөрөвдүгээрт, 2000 онд батлагдсан Виндхүүкийн тунхаглал болон Намибийн үйл ажиллагааны хөтөлбөр нь олон талт энхийг сахиулах ажиллагаанд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, мөн энхийг сахиулах болон энхийг тогтоох бодлогын бүхий л шатанд жендэрийн мэдрэмжтэй хандлагыг нэвтрүүлэх шаардлагыг тодорхойлсон (United Nations 1995).

Иймд НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 1325 дугаар тогтоол нь олон улсын хүний эрхийн хөгжлийн уламжлал, зэвсэгт мөргөлдөөний бодит туршлага, олон улсын эрүүгийн эрх зүйн шинэчлэл, иргэний нийгмийн идэвхтэй оролцооны огтолцолд бүрэлдсэн олон улсын хэм хэмжээний шинэ шат болсон гэж үзэж болно. Тус тогтоол батлагдсаны дараа энх тайван, аюулгүй байдалд эмэгтэйчүүдийн оролцоог дэмжсэн дараах тогтоолууд дагалдан батлагдсан нь энэхүү суурь зарчмыг агуулгын болон хэрэгжилтийн түвшинд гүнзгийрүүлж, бодлогын чиглэл, хэрэгжилтийн механизмыг илүү нарийвчлан тодорхой болгосон.

Хүснэгт 1. *Энх тайван, аюулгүй байдалд эмэгтэйчүүдийн оролцоог дэмжсэн тогтоолуудын гол агуулга, онцлог*

Тогтоол	**Гол агуулга, онцлог**
S/RES/1325 (United Nations Security Council 2000)	Олон улсын энх тайван, аюулгүй байдлын хүрээнд “эмэгтэйчүүд” хэмээх ойлголтыг анх удаа тусгасан. Энхийг тогтоох, сахиулах, бэхжүүлэх бүх шатанд эмэгтэйчүүдийн оролцоог баталгаажуулсан.
S/RES/1820 (United Nations Security Council 2008)	Зэвсэгт мөргөлдөөний үеийн бэлгийн хүчирхийллийг энх тайван, аюулгүй байдлын ноцтой асуудал, мөн дайны гэмт хэрэг болохыг хүлээн зөвшөөрсөн анхны тогтоол юм.

S/RES/1888 (United Nations Security Council 2009a)	1820 дугаар тогтоолын хэрэгжилтийг бэхжүүлэх зорилгоор удирдлагын болон дэмжих механизмыг бий болгосон. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын Зэвсэгт мөргөлдөөн дэх бэлгийн хүчирхийллийн асуудал хариуцсан тусгай төлөөлөгчийн албан тушаалыг бий болгосон.
S/RES/1889 (United Nations Security Council 2009b)	Энх тайвны хэлэлцээ, улс төрийн үйл явц, сэргээн босголтын эхний шатнаас эхлэн эмэгтэйчүүдийн, ялангуяа эмэгтэйчүүдийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх шаардлагыг онцолсон.
S/RES/1960 (United Nations Security Council 2010)	1820 болон 1888 дугаар тогтоолуудын хэрэгжилтийг хянах, тайлагнах албан ёсны механизм, заавал мөрдөх, тайлагнах тогтолцоог бий болгосон.
S/RES/2106 (United Nations Security Council 2013a)	Зэвсэгт мөргөлдөөн дэх бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хариуцлага тооцох чиглэлээр өмнөх тогтоолуудын хэрэгжилтийг бэхжүүлсэн.
S/RES/2122 (United Nations Security Council 2013b)	Эмэгтэйчүүд, энх тайван, аюулгүй байдал хөтөлбөрийг илүү цогц байдлаар хэрэгжүүлэхийг зорьж, эмэгтэйчүүдийн манлайлал, зөрчилдөөнийг шийдвэрлэх үйл явц дахь идэвхтэй оролцоог онцлон тэмдэглэсэн.
S/RES/2242 (United Nations Security Council 2015)	Эмэгтэйчүүд, энх тайван, аюулгүй байдал хөтөлбөрийн хэрэгжилтийг тогтмол үнэлэх зорилгоор албан бус шинжээчдийн бүлгийг байгуулсан. Мөн терроризм, хүчирхийллийн туйлшралаас урьдчилан сэргийлэх асуудлыг уг хөтөлбөртэй уялдуулахыг тусгасан.
S/RES/2467 (United Nations Security Council 2019a)	Зэвсэгт мөргөлдөөний үеийн бэлгийн хүчирхийлэлд “хохирогч төвтэй хандлага”-ын ач холбогдлыг ил тод, тодорхой тусгасан анхны тогтоол бөгөөд хохирогч, амьд үлдэгсдийн хэрэгцээ, эрхийг энхийн хэлэлцээ, шилжилтийн шударга ёс, аюулгүй байдлын салбарын шинэчлэл зэрэг бодлогын үйл явцад заавал тусгах шаардлагыг онцлон тэмдэглэсэн.
S/RES/2493 (United Nations Security Council 2009b)	Эмэгтэйчүүд, энх тайван, аюулгүй байдал хөтөлбөрийн бүх тогтоолын иж бүрэн, үр нөлөөтэй хэрэгжилтийг хангахыг гишүүн улсуудад уриалсан. Мөн мөргөлдөөний дараах сэргээн босголт, тогтворжуулалтын явцад эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих чиглэлээр НҮБ-ын Энхийг цогцлоох комиссын үүргийг бэхжүүлэхийг дэмжсэн.

Хоёр: Бодлогын хэрэгжилтийн дөрвөн тулгуур

НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 1325 дугаар тогтоол болон түүнийг дагалдан батлагдсан тогтоолуудын мандат нь бодлогын хэрэгжилтийн үндсэн дөрвөн тулгуурт хуваагддаг. Эдгээр нь оролцоо, хамгаалал, урьдчилан сэргийлэлт, сэргээн босголт ба нөхөн сэргээлт гэсэн харилцан уялдаа бүхий цогц хүрээг бүрдүүлдэг.

Оролцоо нь үндэсний, бүс нутгийн болон олон улсын байгууллагын хүрээнд шийдвэр гаргах бүх түвшинд эмэгтэйчүүдийн тэгш, бодит оролцоог нэмэгдүүлэхийг шаарддаг. Үүнд: энх тайвны хэлэлцээ, зуучлал, мөргөлдөөнөөс

урьдчилан сэргийлэх болон зохицуулах механизм, энхийг сахиулах ажиллагаанд цэрэг, цагдаа, иргэний албан хаагчийн хувиар оролцох, НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын Тусгай төлөөлөгч зэрэг өндөр түвшний манлайллын бүтэц багтана. Энэ нь эмэгтэйчүүдийн оролцоог зөвхөн тоон үзүүлэлтээр хэмжих бус, харин бодлого, шийдвэрийн хэрэгжилтэд бодит нөлөө үзүүлэх чанарын оролцоог баталгаажуулахад чиглэгддэг.

Хамгаалал нь зэвсэгт мөргөлдөөн, хүмүүнлэгийн онцгой байдал, дүрвэгсдийн хуаран зэрэг эмзэг нөхцөлд эмэгтэйчүүд, охидыг бэлгийн болон жендэрт суурилсан хүчирхийллээс хамгаалах үүргийг тодорхойлдог. Энэхүү чиглэл нь эмэгтэйчүүдийг зөвхөн мөргөлдөөний хохирогч бус, харин эрх бүхий этгээд хэмээн үзэх хүний эрхийн хандлагад суурилдаг. Энэ хүрээнд олон улсын болон үндэсний эрх зүйн зохицуулалтыг хэрэгжүүлэх, зөрчил гаргасан этгээдүүдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, ял шийтгэлээс зугтах байдлыг бууруулах, хохирогч төвтэй хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлэх нь чухал ач холбогдолтой.

Урьдчилан сэргийлэлт нь жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх бодлого, стратегийг системтэйгээр бэхжүүлэхэд чиглэдэг. Энэ нь зөвхөн хүчирхийллийн илрэлд хариу үзүүлэхээс гадна мөргөлдөөн, хүчирхийллийн бүтцийн шалтгаан болох жендэрийн тэгш бус байдал, ялгаварлан гадуурхалт, эрх зүйн болон институцийн сул байдлыг бууруулахад чиглэсэн урт хугацааны бодлогын арга хэмжээг хамардаг. Энэ хүрээнд олон улсын болон үндэсний эрх зүйн хариуцлагын механизмыг хэрэгжүүлэх, олон улсын эрх зүйн зөрчил үйлдсэн этгээдүүдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах хууль тогтоомжийг боловсронгуй болгох шаардлагатай. Мөн орон нутгийн эмэгтэйчүүдийн энх тайвны санаачилга, зөрчилдөөнийг шийдвэрлэх үйл явцад тэдний оролцоог дэмжих нь урьдчилан сэргийлэх бодлогын салшгүй бүрэлдэхүүн болдог.

Сэргээн босголт ба нөхөн сэргээлт нь мөргөлдөөн болон хямралын дараа дүрвэгсдийн хуаран, түр суурьшлын бүс зэрэг эмзэг орчинд иргэний болон хүмүүнлэгийн шинж чанарыг хүндэтгэх, хамгааллын баталгааг хангах, мөн төлөвлөлт, зохион байгуулалтын бүх шатанд эмэгтэйчүүд, охидын хэрэгцээг жендэрийн мэдрэмжтэй байдлаар хэрэгжүүлэхийг шаарддаг.

Эдгээр дөрвөн тулгуурыг системийн болон цаг хугацааны хэмжээсээр уялдуулан авч үзэх нь эмэгтэйчүүд, энх тайван ба аюулгүй байдлын хөтөлбөрийг зөвхөн салангид бодлогын багц бус, харин динамик, үе шаттай, харилцан хамааралтай аюулгүй байдлын засаглалын загвар хэмээн ойлгох үндэслэлийг бүрдүүлж байна. Тухайлбал: оролцооны тулгуур нь хамгааллын бодлогын чанар, хүртээмж, бодит үр нөлөөг бэхжүүлж, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн дуу хоолой тусгалаа олох нөхцөлийг бүрдүүлдэг. Харин хамгааллын тулгуур нь урьдчилан сэргийлэлтийн бодлогын итгэлцэл, үр нөлөөг нэмэгдүүлж, эрх зүйн болон хариуцлагын механизмыг бататгана. Цаашлаад урьдчилан сэргийлэлтийн тулгуур нь зэвсэгт мөргөлдөөн, хямралын бүтцийн болон суурь шалтгааныг бууруулснаар тогтвортой сэргээн босголт, нөхөн сэргээлтийн бодлогын суурийг бүрдүүлэх үндэс болдог. Эдгээр тулгуурыг цаг хугацааны хэмжээсээр авч үзвэл мөн шаталсан уялдаа ажиглагдана. Урьдчилан сэргийлэлт нь мөргөлдөөнөөс өмнөх үе шатанд илүү чиглэгддэг бол хамгаалал нь мөргөлдөөний явцад хүний эрх,

аюулгүй байдлыг баталгаажуулахад төвлөрнө. Сэргээн босголт, нөхөн сэргээлт нь мөргөлдөөний дараах үе шатанд тогтвортой институцийн суурийг бэхжүүлэхэд чиглэнэ. Харин оролцоо нь эдгээр бүх үе шатанд огтлолцож үйлчилдэг хөндлөн чиглэлийн тулгуур бөгөөд бодлогын төлөвлөлт, хэрэгжилтийн бүх түвшинд нөлөөлөх шинжтэй.

Гурав. Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахад анхаарах асуудлууд

Олон талт олон улсын тогтолцоонд жендэрийн тэгш байдлыг хангах, хүний эрхийг хэрэгжүүлэх үндсэн хариуцлага нь НҮБ-ын гишүүн улсуудын бүрэн эрх, үүрэгт хамаардаг. Энэ хүрээнд НҮБ-ын 1325 дугаар тогтоол нь Эмэгтэйчүүд, энх тайван ба аюулгүй байдлын хөтөлбөр (ЭЭТАБХ)-ийн үндэсний түвшний хэрэгжилтийг баталгаажуулах, түүний дотор Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө (ҮҮАТ) боловсруулах замаар уг хөтөлбөрийн дөрвөн тулгуур чиглэлийг бодитой хэрэгжүүлэх юм. Тус тогтоол батлагдсаны дараах эхний жилүүдэд ҮҮАТ нь НҮБ-ын түвшинд шууд хэрэгжилтийн үндсэн механизм болж төлөвшөөгүй. НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн Ерөнхийлөгчийн 2004 болон 2005 оны мэдэгдлүүдэд гишүүн улсуудыг ЭЭТАБХ-ийг үндэсний бодлогын түвшинд хэрэгжүүлэх бодит механизм болгон ҮҮАТ боловсруулахыг уриалснаар (United Nations Security Council 2004) хэрэгжиж эхэлсэн байдаг.

ҮҮАТ ихэвчлэн тухайн улсын үндэсний хөгжлийн бодлого, жендэрийн тэгш байдлын стратеги, энх тайван болон аюулгүй байдлын салбарын бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан боловсруулагддаг. Энэ нь ЭЭТАБХ-ийг салангид бус, харин төрийн нэгдсэн бодлогын хүрээнд хэрэгжүүлэх зохицуулалтыг хангах зорилготой. ҮҮАТ-г Дани 2005 онд баталсан нь 1325 дугаар тогтоолын хэрэгжилтийг үндэсний түвшинд хэрэгжүүлэх чиглэлд хийсэн анхны бодит алхам болсон. Өнөөдрийн байдлаар дэлхийн 117 улс 1325 дугаар тогтоол болон ЭЭТАБХ-ийн бусад холбогдох тогтоолуудыг хэрэгжүүлэх ҮҮАТ боловсруулж, баталсан байна. (Women, Peace and Security Focal Points Network, n.d.)



Зураг 1. *ҮҮАТ баталсан улсууд*

Цаг хугацааны явцад олон улс анхны баталсан ҮҮАТ-гөө хоёр, гурав, цаашлаад дөрөв, тав дахь удаагаа шинэчлэн сайжруулж, боловсруулсан нь ЭЭТАБХ-ийн хэрэгжилт нэг удаагийн бодлогын баримт бичгээр хязгаарлагдах бус, харин үнэлгээ, туршлага, сургамж, суралцах чадавхад суурилсан тасралтгүй хөгжлийн үйл явц болохыг илтгэнэ. Үе шаттайгаар шинэчлэгдэж буй ҮҮАТ-нүүд нь бодлогын үр нөлөөг нэмэгдүүлэх, хэмжигдэхүйц шалгуур үзүүлэлтийг тодорхой болгох, хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог боловсронгуй болгох, санхүүжилтийн ил тод байдал болон зардлын төлөвлөлтийг баталгаажуулах, мөн салбар хоорондын уялдаа, зохицуулалтыг бэхжүүлэх чиглэлд чанарын ахиц гаргаж буйг харуулж байна. Мөн ҮҮАТ-нүүд жендэрийн мэдрэмжтэй, төсөв, өгөгдөлд суурилсан, тайлагнал, нотолгоонд тулгуурласан, бодлого боловсруулах хандлага, иргэний нийгмийн оролцоог институцчилсэн хэлбэрээр баталгаажуулах зэрэг шинэ элементүүдийг тусгаснаараа бодлогын засаглалын чанар, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх чиглэлд ахиц гаргаж байна.

ҮҮАТ боловсруулах, төлөвлөх, хэрэгжүүлэх үйл явцад улс орнууд харилцан адилгүй арга зүй, зохион байгуулалтын загвар ашигладаг бөгөөд зорилт тодорхойлолт, хэрэгжих хугацаа, агуулгын хамрах хүрээ, төсвийн баталгаажуулалт, хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцооны хувьд ялгаатай байна. Ийм ялгаа нь зөвхөн бодлогын тэргүүлэх чиглэлээс гадна чадавх, санхүүгийн нөөц, улс төрийн дэмжлэг, иргэний нийгмийн оролцооны түвшин зэрэг хүчин зүйлстэй уялддаг.

ҮҮАТ боловсруулалтын үе шат, тусгагдаж буй шинэ хандлага, тулгарч буй сорилтуудын талаар авч үзье.

ҮҮАТ-ний боловсруулах үе шат: ҮҮАТ боловсруулах үйл явцыг эхлүүлэхэд улс төрийн түвшний тууштай амлалт, бодлогын дэмжлэг зайлшгүй шаардлагатай байдаг. Энэ үе шатанд төлөвлөгөө боловсруулах үйл явцыг тэргүүлэн зохион байгуулах яам, байгууллагыг тодорхойлж, бодлогын өмчлөл болон хариуцлагын хүрээг тогтоодог. Ихэнх улс оронд тодорхой нэг яам ерөнхий зохицуулагчийн үүргийг гүйцэтгэдэг боловч бодлогын олон талт шинжийг харгалзан салбар хоорондын ажлын хэсэг байгуулж, ҮҮАТ боловсруулах үйл явцыг удирдан чиглүүлж байна. Үүнтэй зэрэгцэн бодлогын агуулга боловсруулах, нөхцөл байдлын үнэлгээ хийх, зорилт болон шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлох үүрэг бүхий мэргэжлийн түвшний ажлын хэсгийг байгуулж, техникийн шинжтэй ажлыг хариуцуулдаг.

ЭЭТАБ-ын дөрвөн тулгуур чиглэлтэй уялдуулан тухайн улсын бодит нөхцөл байдал, бодлогын орчны сул тал, боломж, нөөц чадавхыг тодорхойлох зорилгоор суурь судалгаа, нөхцөл байдлын үнэлгээ хийх нь ҮҮАТ боловсруулах үйл явцын зайлшгүй чухал үе шат болдог. Энэ нь бодлогын зорилго, тодорхой зорилтуудыг бодитой тодорхойлох үндэслэл болж, цаашдын хэрэгжилтийн ахиц дэвшлийг хэмжих суурь түвшинг тогтоох ач холбогдолтой. Нотолгоонд суурилсан үнэлгээний үр дүнд тодорхой хугацаанд хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ, хариуцсан байгууллага, хэмжигдэхүйц шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлж, бодлогын хэрэгжилтийг хянах хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай. Хэмжигдэхүйц шалгуур үзүүлэлт болон суурь түвшин тодорхойлоогүй төлөвлөгөө нь бодлогын ахиц, үр нөлөөг системтэй үнэлэх боломжийг хязгаарлаж, тайлагнал, хариуцлагын механизм сулрах эрсдэлийг

дагуулдаг байна.

ҮҮАТ боловсруулах үйл явцад төрийн байгууллагуудаас гадна иргэний нийгмийн байгууллагууд, төрийн бус байгууллагууд, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагууд, мөн олон улсын хөгжлийн түншүүдийн оролцоо чухал ач холбогдолтой. Иймм олон талт оролцоо нь бодлогын чанар, легитим шинж, хэрэгжилтийн тогтвортой байдлыг хангах үндэс болдог. Энэхүү хамтын ажиллагаа нь салбар дундын ажлын хэсэгт төлөөлөл оролцуулах, зөвлөлдөх уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах, төлөвлөгөөний төслийг олон нийтийн оролцоотойгоор хэлэлцүүлэх зэрэг хэлбэрээр хэрэгжиж болно.

ҮҮАТ нь зөвхөн стратегийн зорилт тодорхойлсон баримт бичиг бус, харин хэрэгжилтийн институцийн бүтэц, тайлагналын механизм, хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог тодорхой тусгасан цогц бодлогын баримт бичиг байх шаардлагатай. Өөрөөр хэлбэл: бодлогын зорилтыг тодорхойлохоос гадна түүнийг хэн, хэрхэн, ямар хугацаанд, ямар шалгуур үзүүлэлтээр хэрэгжүүлэхийг тодорхой заасан байх нь бодлогын үр нөлөөг баталгаажуулах үндэс болдог. Иймм хүрээнд өгөгдөл цуглуулах тогтолцоо, суурь түвшин, хэмжигдэхүйц шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлох нь хэрэгжилтийг системтэй хянах, ахиц дэвшлийг үнэлэх, ил тод байдал болон хариуцлагыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой. Мөн хангалттай төсөв, санхүүжилтийн баталгаажуулалтгүйгээр ҮҮАТ-ийг бодитоор хэрэгжүүлэх боломж хязгаарлагдмал тул төлөвлөгөө боловсруулах үе шатанд зардлын нарийвчилсан тооцоолол хийж, түүнийг улсын төсөв болон холбогдох санхүүжилтийн эх үүсвэртэй уялдуулах нь бодлогын хэрэгжилтийг хангах суурь нөхцөл болдог байна.

Хүснэгт 2. *ҮҮАТ боловсруулах үйл явц*

№	Үе шат	Гол үйл ажиллагаа	Хариуцсан оролцогчид	Үр дүн
1.	Улс төрийн амлалт ба үйл явцыг эхлүүлэх	ҮҮАТ боловсруулах шийдвэр гаргах, тэргүүлэх яамыг тодорхойлох, салбар хоорондын ажлын хэсэг байгуулах	Засгийн газар, холбогдох яамд,	Бодлогын өмчлөл, зохицуулалт
2.	Суурь судалгаа, нөхцөл байдлын үнэлгээ	ЭЭТАБ-ын дөрвөн тулгуур чиглэлээр нөхцөл байдлыг үнэлэх	Судалгааны байгууллага, яамд, иргэний нийгэм	Суурь түвшин, бодлогын хэрэгцээ тодорхойлох
3.	Оролцогч талуудын зөвлөлдөх үйл явц	Иргэний нийгэм, эмэгтэйчүүд болон судалгааны байгууллага, олон улстай зөвлөлдөх	Төрийн байгууллага, ТББ, олон улсын байгууллага	Бодлогын агуулга илүү бодитой, легитим болох
4.	Стратеги, зорилт тодорхойлох	Зорилго, зорилтууд, арга хэмжээ, хэрэгжүүлэгч байгууллага тодорхойлох	Ажлын хэсэг, бодлогын шинжээчид	ҮҮАТ-ын бүтэц, бодлогын хүрээ

5.	Шалгуур үзүүлэлт ба Хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо	Хэмжигдэхүйц индикатор, суурь түвшин, өгөгдөл цуглуулах аргачлал боловсруулах	Төрийн байгууллага, судлаачид	Хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо
6.	Төсөв, санхүүжилтийн төлөвлөлт	Зардлын тооцоо гаргах, улсын төсөв болон донор санхүүжилттэй уялдуулах	Сангийн яам, холбогдох байгууллагууд	Санхүүгийн баталгаажуулалт
7.	Батлах ба хэрэгжилтийг эхлүүлэх	YYAT-ийг Засгийн газар/Парламент батлах, хэрэгжилтийн зохицуулалт эхлүүлэх	Засгийн газар, парламент	Албан ёсны бодлогын баримт бичиг
8.	Хяналт-шинжилгээ, тайлагнал	Ахиц дэвшлийг хэмжих, тайлагнах, шинэчлэх	Засгийн газар, иргэний нийгэм	Ил тод байдал, бодлогын сайжруулалт

YYAT-д тусгагдаж буй шинэ хандлагууд: Сүүлийн жилүүдэд ЭЭТАБХ-ийн хүрээнд батлагдаж буй YYAT-нүүд нь өргөн хүрээний, тунхаглалын шинжтэй амлалтаас илүү тодорхой зорилт, хэмжигдэхүйц үр дүн, нутагшсан хэрэгжилт, технологийн өөрчлөлтийг харгалзсан бодлогын илүү нарийвчилсан хүрээ рүү шилжиж байна. Үүнтэй уялдан улс орнууд YYAT-ийг боловсруулах, хэрэгжүүлэх арга зүй, институцийн зохион байгуулалт, агуулгын цар хүрээний хувьд дараах үндсэн өөрчлөлт, хувьслын чиг хандлагыг илэрхийлж байна. Тухайлбал:

1. Шинээр гарч буй болон уламжлалт бус аюулгүй байдлын сорилтуудыг бодлогын хүрээнд нэгтгэх хандлага: YYAT-нүүд нь уламжлалт зэвсэгт мөргөлдөөний хүрээнд төвлөрсөн аюулгүй байдлын ойлголтоос давж, дэлхий дахинд тулгамдаж буй шинээр гарч ирж буй болон уламжлалт бус аюулгүй байдлын сорилтуудыг бодлогын хүрээнд системтэйгээр нэгтгэх хандлагатай болж байна. ЭЭТАБХ-ийн агуулга нь зөвхөн мөргөлдөөний үеийн хамгаалал, оролцооны асуудлаар хязгаарлагдах бус, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, тогтвортой хөгжлийн хүчин зүйлстэй огтлолцох болсон нь аюулгүй байдлын ойлголтыг өргөжүүлж буйг илэрхийлнэ.

- Уур амьсгалын аюулгүй байдал: Уур амьсгалын өөрчлөлт нь нийгмийн тогтвортой байдал, шилжилт хөдөлгөөн, амьжиргааны эх үүсвэр, нөөцийн хүртээмжид жендэрийн ялгаатай нөлөө үзүүлдэг болохыг бодлогын түвшинд хүлээн зөвшөөрөх хандлага нэмэгдэж байна. Үүний үр дүнд YYAT-нд уур амьсгалын эрсдэлийг эмэгтэйчүүд, охидын эмзэг байдал, оролцооны боломжтой уялдуулан авч үзэх болсон.

- Цахим аюулгүй байдал ба хиймэл оюун: YYAT-нд цахим орчин дахь жендэрт суурилсан хүчирхийлэл, цахим гүтгэлэг, эмэгтэйчүүдийн эсрэг үзэл, түүнчлэн хиймэл оюун болон бусад шинэ технологийн хэрэглээ, буруу хэрэглээний эрсдэлийг бодлогын хүрээнд тусгаж эхэлсэн. Мөн технологийн хөгжил нь жендэрийн тэгш бус байдлыг улам гүнзгийрүүлэх, эсвэл бууруулах хоёрдмол боломжтойг хүлээн зөвшөөрч буй бодлогын хувьсал юм.

- Цар тахлын дараах сөрөн тэсвэрлэх чадавх: Ковид-19 цар тахлын туршлага нь

хүний аюулгүй байдал, нийгмийн хамгаалал, эдийн засгийн сэргэлтэд жендэрийн ялгаатай нөлөөлөл үүсгэдгийг тод харуулсан. Үүний улмаас YYAT-нд гамшиг, цар тахал, хямралын нөхцөлд эмэгтэйчүүдийн оролцоо, хамгаалал, нийгмийн хамгааллын хүртээмжийг тусгах, институцийн сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх шаардлагыг бодлогын түвшинд нэгтгэх хандлага ажиглагдаж байна.

2. Засгийн газрын бүх түвшнийг хамарсан хэрэгжилтийн загвар: YYAT нь нэг яам дангаар удирдан хэрэгжүүлэх загвараас татгалзаж, салбар хоорондын хамтын ажиллагаанд суурилсан, засгийн газрын бүх түвшнийг хамарсан зохицуулалтын тогтолцоог бүрдүүлэх чиглэлд шилжиж байна. Энэ нь ЭЭТАБ-ыг бодлогын хүрээнд хязгаарлах бус, үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах, хууль зүй, нийгмийн хамгаалал, боловсрол зэрэг олон салбарт огтлолцсон цогц бодлогын хэрэгсэл болгох оролдлого юм.

- Салбар хоорондын зохицуулалт: Бангладеш, Өмнөд Солонгос улсууд батлан хамгаалах, хууль зүй, нийгмийн хамгаалал зэрэг яамд оролцсон “зохицуулалтын бүлэг” байгуулж, хамтын удирдлагын загварыг нэвтрүүлж байна. Ийм бүтэц нь бодлогын давхардлыг бууруулах, мэдээллийн солилцоог сайжруулах, хариуцлагын механизмыг тодорхой болгох замаар YYAT-ийг илүү үр нөлөөтэй хэрэгжүүлэх институцийн суурийг бэхжүүлдэг.

- Эрэгтэйчүүдийн оролцоо: Жендэрийн тэгш байдал зөвхөн эмэгтэйчүүдийн асуудал бус, нийгмийн бүтцийн болон эрх мэдлийн харилцааны асуудал хэмээн үзэх хандлага бэхжиж байна. Үүний хүрээнд эрэгтэйчүүд, хөвгүүдийг жендэрийн тэгш байдлын бодлогын холбоотон болгон татан оролцуулах чиглэл тодорхой болж, YYAT-нд тусгагдах болсон. Энэ нь жендэрийн тэгш байдлын хариуцлагыг нийгмийн нийт гишүүдэд хуваалцах, урт хугацааны тогтвортой өөрчлөлтийг дэмжих ач холбогдолтой.

3. Бүтцийн болон хариуцлагын тогтолцооны шинэчлэл: YYAT нь “процессоос үр дүн рүү” шилжих бодлогын чиг хандлагыг илэрхийлж, хэмжигдэхүйц, нотолгоонд суурилсан, хариуцлагатай хэрэгжилтийн тогтолцоог илүү чухалчлах болсон.

- Санхүүжилтийн баталгаажуулалт: YYAT батлагдах үедээ тодорхой төсөв тусгагдаагүй байсан нь хэрэгжилтийн бодит боломжийг хязгаарлаж ирсэн байна. 2024-2025 онд батлагдсан төлөвлөгөөнүүдэд төсөв суугдаж, тодорхой санхүүгийн хуваарилалттайгаар батлагдах болсон нь бодлогын хэрэгжилтийг институцчлэх чиглэлд ахиц гарч буйг илтгэнэ. Энэхүү хандлага нийт төлөвлөгөөнүүдийн хувьд хангалттай түвшинд хүрээгүй хэвээр байгаа нь санхүүжилтийн тогтвортой байдал, үндэсний өмчлөл, хариуцлагын механизмтай шууд уялдсан сорилт хэвээр байгааг харуулж байна.

- Дэвшилтэт мониторинг ба үнэлгээ: Филиппиний YYAT дөрөв дэх удаагаа шинэчлэгдэн батлагдахдаа хяналт-шинжилгээ, үнэлгээ, хариуцлага ба суралцах тогтолцоог нэвтрүүлж, иргэний нийгмийн хяналт, оролцоог албан ёсоор тусгасан нь бодлогын ил тод байдал, тайлагнал, үр нөлөөг бэхжүүлэхэд чиглэсэн байна. Энэ нь YYAT-г зөвхөн тайлагналын баримт бичиг бус, бодит өөрчлөлт бий болгох, суралцах чадавхыг дэмжих хэрэгсэл болгон хөгжүүлэхэд ач холбогдолтой.

YYAT-ний хэрэгжилтэд тулгарч буй сорилт: YYAT боловсруулах,

хэрэгжүүлэх үйл явцад улс орнуудын туршлагаас харахад нийтлэг хэд хэдэн бүтэц, засаглал, нөөц, оролцооны шинжтэй сорилтууд илэрч байна. Эдгээр сорилтууд нь бодлогын төлөвлөлтөөс хэрэгжилт, үнэлгээ хүртэлх бүхий л үе шатанд тодорхой нөлөөлж, ЭЭТАБХ-ийн бодит үр нөлөөг хязгаарлах хүчин зүйл болж байна. Судалгааны болон практик туршлагад тулгуурлан эдгээр сорилтуудыг дараах үндсэн чиглэлүүдээр ангилан авч үзлээ.

1. Улс төрийн эрмэлзэл, удирдлагын тогтвортой байдал: Улс төрийн дэмжлэг тогтворгүй байх нь YYAT-ний хэрэгжилтийг сулруулах гол хүчин зүйлсийн нэг юм. Төлөвлөгөөг батлаад орхих нь хангалтгүй бөгөөд түүнийг бодит үр дүнд хүргэхийн тулд төрийн дээд түвшний тогтвортой манлайлал, стратегийн удирдлага, хяналт-шинжилгээ, тайлагналын хариуцлагатай тогтолцоо шаардлагатай. Засгийн газар солигдох, бодлогын тэргүүлэх чиглэл өөрчлөгдөх, эсвэл улс төрийн анхаарал өөр асуудалд шилжих нөхцөлд өмнөх төлөвлөгөөний залгамж чанар алдагдах, хэрэгжилтийн явц тасалдах, санхүүжилт буурах эрсдэл өндөр байдаг. Иймээс улс төрийн дэмжлэг нь зөвхөн батлах үе шатанд бус, хэрэгжилтийн бүх хугацаанд тогтвортой хадгалагдах шаардлагатай.

Мөн байгууллага хоорондын уялдаа, зохицуулалт сул байх нь хэрэгжилтийн үр нөлөөг бууруулдаг. YYAT нь батлан хамгаалах, гадаад харилцаа, хууль зүй, нийгмийн хамгаалал, боловсрол зэрэг олон салбарын оролцоог шаарддаг цогц бодлогын баримт бичиг юм. Яам, агентлагуудын хоорондын мэдээлэл солилцоо, хамтын ажиллагаа хангалтгүй байх, үүрэг хариуцлагын тодорхой хуваарилалтгүй байх тохиолдолд хэрэгжилт удаашрах, бодлогын давхардал болон хийдэл үүсэх нөхцөлийг бүрдүүлдэг.

2. Санхүүжилт ба нөөцийн хомсдол: Санхүүжилтийн тодорхой бус байдал нь YYAT-ийн хэрэгжилтэд тулгардаг хамгийн нийтлэг сорилтын нэг юм. YYAT-ний 29 нь буюу нийт төлөвлөгөөний 26 хувь нь тодорхой төсөвтэй батлагддаг (UN Women, 2025) гэсэн судалгаа байдаг. Эндээс YYAT-нүүд бодлогын зорилт, арга хэмжээг тодорхойлсон боловч тэдгээрийг хэрэгжүүлэх төсөвгүйгээр батлагддагийг харуулж байна. Төсвийн суугдаагүй төлөвлөгөө нь стратегийн зорилтыг тунхаглалын шинжтэй, төлөвлөгөөний үр нөлөөг бодитоор хангах боломжийг хязгаарладаг. Нөгөө талаас, хөгжиж буй улс орнуудын YYAT боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь гадаадын донор болон олон улсын байгууллагын санхүүжилтээс ихээхэн хамааралтай байдаг. Энэ нь богино хугацаанд бодлогын хэрэгжилтийг дэмжих, чадавх бэхжүүлэх боломж бүрдүүлдэг ч урт хугацаанд санхүүгийн тогтвортой байдал, үндэсний өмчлөл, бодлогын бие даасан байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэл дагуулдаг. Энэ хамаарал нь бодлогын тэргүүлэх чиглэл гадаад санхүүжилтийн нөхцөлөөс шалтгаалах, мөн донорын циклтэй уялдан хэрэгжилтийн тасалдал үүсэх магадлалыг нэмэгдүүлдэг.

3. Олон нийтийн оролцоо ба төлөөлөл: YYAT боловсруулах, хэрэгжүүлэх үйл явцад иргэний нийгмийн байгууллагууд, ялангуяа эмэгтэйчүүдийн эрхийн чиглэлээр ажилладаг сүлжээ, орон нутгийн байгууллагуудын оролцоо бодит бус, хэлбэр төдий байх тохиолдол олон улсын туршлагад түгээмэл ажиглагддаг. Ийм нөхцөлд оролцооны механизм нь зөвхөн зөвшилцөх шинжтэй, шийдвэр гаргах түвшинд нөлөөлөх бодит боломжгүй байснаар төлөвлөгөө нь орон нутгийн бодит хэрэгцээ, туршлага, эрсдэлийн үнэлгээнд тулгуурлаагүй, дээрээс доош чиглэсэн

шинжтэй бодлогын баримт бичиг болон хувирах эрсдэлтэй. Мөн “эмэгтэйчүүд, энх тайван, аюулгүй байдал” гэх нэршил нь асуудлыг зөвхөн эмэгтэйчүүдийн хүрээнд хязгаарласан мэт ойлголт төрүүлэх хандлагатай байдаг. Үүний улмаас эрэгтэйчүүд, ялангуяа шийдвэр гаргах түвшний манлайлал, аюулгүй байдлын салбарын оролцогчдын оролцоо хангалтгүй байх явдал ажиглагддаг. Жендэрийн тэгш байдал нь нийгмийн бүтцийн, харилцааны шинжтэй асуудал тул эрэгтэйчүүдийг бодлогын хэрэгжилт, хандлагын өөрчлөлтийн үйл явцад идэвхтэй татан оролцуулах замаар тогтвортой байдлыг хангах боломжтой.

4. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцооны сул тал: YYAT-д зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагааны жагсаалт тодорхой тусгагдсан байдаг боловч тэдгээрийн үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлт, суурь түвшин, хэрэгжилтийн хугацааг тусгадаггүй. Энэ нөхцөлд бодлогын хэрэгжилтийн бодит ахиц дэвшил, нөлөөлөл, үр нөлөөг системтэйгээр үнэлэх боломж хязгаарлагдаж, гүйцэтгэлийн хэмжигдэхүйц байдал сулрах эрсдэл үүсдэг. Түүнчлэн статистик мэдээлэл, чанарын болон тоон судалгаанд суурилсан өгөгдлийн хомсдол нь хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцооны үр нөлөөг бууруулдаг. Өгөгдөлд суурилсан бодлого боловсруулах, хэрэгжилтийг нотолгоонд тулгуурлан дүгнэх чадавх бүрдээгүй нөхцөлд YYAT нь бодит өөрчлөлт бий болгох хэрэгсэл бус, тайлагналын шинж давамгайлсан баримт бичиг болон хувирах эрсдэлтэй.

5. Шинэ сорилтууд: Сүүлийн жилүүдэд дэлхийн аюулгүй байдлын орчин эрс өөрчлөгдөж, YYAT-ний хүрээ, агуулгыг улам нарийн төвөгтэй болгож байна. Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй шилжилт хөдөлгөөн, нөөцийн хомсдол, хүмүүнлэгийн хямралын давтамж, цар хүрээний өсөлт, цахим аюулгүй байдлын эрсдэл, хэт даврагч үзэл, зэвсэгт мөргөлдөөний хэлбэрийн хувьсал зэрэг шинэ сорилтууд нь ЭЭТАБ-ын бодлогын хамрах хүрээг өргөжүүлж, улам цогц, салбар дундын хандлага шаарддаг болсон. Аюулгүй байдлын уламжлалт ойлголт тэлж, эрсдэлийн шинж чанар өөрчлөгдөх тусам YYAT-ний уялдаа, дасан зохицох чадавх чухал ач холбогдолтой болж байна. Мөн зарим бүс нутагт эмэгтэйчүүдийн эрхийн төлөөх идэвхтэн, иргэний нийгмийн байгууллагуудад чиглэсэн дарамт, заналхийлэл, халдлагын тохиолдол нэмэгдэж байгаа нь YYAT-ний хэрэгжилтэд сорилт болж байна. Иргэний нийгмийн аюулгүй байдал, оролцооны боломж хязгаарлагдах нь ЭЭТАБХ-ийн оролцоонд суурилсан зарчмыг сулруулах эрсдэлтэй. Иймээс YYAT-ын тогтвортой хэрэгжилт нь аюулгүй байдлын өөрчлөгдөж буй орчинд дасан зохицох чадавх, хүний эрхийн хамгаалалтын баталгаатай орчин, иргэний нийгмийн аюулгүй, идэвхтэй оролцоотой салшгүй холбоотой асуудал юм.

ДҮГНЭЛТ

Эмэгтэйчүүд, энх тайван, аюулгүй байдлын хөтөлбөр нь сүүлийн арав гаруй жилийн хугацаанд үзэл баримтлалын шинжтэй тунхаглалын шатнаас хальж, бодит хэрэгжилтийн чадавх, бодлогын уялдаа бүхий дараагийн шатанд шилжээд байна. НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 1325 дугаар тогтоол нь улс орнуудыг жендэрийн тэгш, утга учиртай оролцоог аюулгүй байдлын бодлогын салшгүй бүрэлдэхүүн хэсэг болгон төлөвшүүлэхийг уриалсан бол өнөөдөр гол анхаарал нь “энэ амлалтыг хэрхэн үр дүнтэй, хэмжигдэхүйц байдлаар хэрэгжүүлэх вэ” гэсэн бодлогын практик асуудалд төвлөрч байна.

Нэгдүгээрт, ЭЭТАБХ нь уламжлалт энхийг сахиулах ажиллагаа, мөргөлдөөний дараах сэргээн босголтын хүрээнээс хальж, үндэсний аюулгүй байдлын стратеги, батлан хамгаалах бодлого, гадаад бодлогын суурь баримт бичгүүдтэй илүү нягт уялдах чиг хандлага давамгайлж байна. Зарим улс орон ЭЭТАБ-ыг Үндэсний аюулгүй байдлын стратеги, Батлан хамгаалах бодлого зэрэг бодлогын баримт бичгүүдэд шууд тусган, жендэрийн асуудлыг тусгаж эхэлсэн нь салбар хоорондын уялдаа, бодлого гүнзгийрч буйг илтгэнэ.

Хоёрдугаарт, YYAT-ний чанарын шинэ үе шат ажиглагдаж байна. YYAT-нүүд анх батлагдахдаа ерөнхий зорилт, үйл ажиллагааны жагсаалт хэлбэртэй байсан бол сүүлийн үед хэмжигдэхүйц шалгуур үзүүлэлт, зардлын нарийвчилсан тооцоо, хяналт-шинжилгээ, үнэлгээний тодорхой механизм, тайлагналын давтамж зэрэг хэрэгжилтийн бодит суурийг илүү нарийвчлан тусгах болсон.

Гуравдугаарт, ЭЭТАБХ-ийн хүрээ өргөжин, шинээр гарч буй болон уламжлалт бус аюулгүй байдлын сорилтуудтай холбогдох болсон. Үүнд: хэт даврагч үзэл, радикалчлалын эсрэг бодлого; кибер аюулгүй байдал болон цахим орчин дахь жендэрт суурилсан хүчирхийлэл; уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй эмэгтэйчүүдийн эмзэг байдал; шилжилт хөдөлгөөн; хиймэл оюуны нөлөөлөл зэрэг орчин үеийн аюулгүй байдлын асуудлууд багтаж байна. Энэ нь хүний аюулгүй байдал болон иж бүрэн аюулгүй байдлын үзэл баримтлалтай илүү уялдах хандлагатай болгож байна.

Дөрөвдүгээрт, олон улсын түвшинд ЭЭТАБ нь жижиг, дунд улсуудын зөөлөн хүчний бодлогын нэг хэрэгсэл болон ашиглагдах чиг хандлага ажиглагдаж байна. Зарим улс ЭЭТАБ-ыг гадаад бодлогын тэргүүлэх чиглэл болгон тодорхойлж, энхийг дэмжих ажиллагаанд эмэгтэй алба хаагчдын оролцоог нэмэгдүүлэх зэргээр олон улсад хэм хэмжээ түгээн дэлгэрүүлэгчийн байр суурыа бэхжүүлж байна.

Тавдугаарт, ЭЭТАБ-ын хүрээнд хариуцлага болон өгөгдөлд суурилсан бодлогын эрэлт нэмэгдэж байна. Жендэрийн үнэлгээнд суурилсан өгөгдөл, тайлан, иргэний нийгмийн хараат бус үнэлгээ зэрэг нь бодлогын үр нөлөөг хэмжих, шаардлагатай тохиолдолд засварлах салбарын чадавхыг бэхжүүлж байна. Энэ нь ЭЭТАБ-ыг зөвхөн улс төрийн амлалт бус, хэмжигдэхүйц, гүйцэтгэлд суурилсан бодлогын чиглэл болгон хөгжүүлэхэд ач холбогдолтой.

ЭЭТАБХ нь зөвхөн хүйсийн тэгш байдлыг дэмжих бодлогын хүрээгээр хязгаарлагдахгүй, харин аюулгүй байдлын засаглалын чанар, тогтвортой хөгжил, үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхтай уялдсан бодлогын цогц тогтолцоо болон төлөвшиж байна. Ийм нөхцөлд ЭЭТАБ-ын цаашдын хөгжлийн шалгуур нь тунхаглалын шинжтэй амлалтаар хэмжигдэх бус, харин хэрэгжилтийг институцийн түвшинд бэхжүүлэх, тогтвортой санхүүжилтийн механизм бүрдүүлэх, салбар хоорондын бодлогын уялдааг хангах, улмаар хэмжигдэхүйц, нотолгоонд суурилсан үр дүнгээр бодитой үнэлэгдэхэд оршино.

Эшлэл авсан сурвалж, судалгааны бүтээл:

1. Nowrojee, Binaifer. 1996. *Shattered Lives: Sexual Violence during the Rwandan Genocide and Its Aftermath*. With Human Rights Watch. Human Rights Watch.
2. *Rome statute of the International Criminal Court*. 2021. International Criminal Court.

3. United Nations. 1995. *Beijing Declaration and Platform for Action: Fourth World Conference on Women*. United Nations. *https://www.un.org/womenwatch/daw/beijing/pdf/BDPfA%20E.pdf*.
4. United Nations Security Council. 2000. *Security Council Resolution 1325*. S/RES/1325(2000). United Nations Security Council. https://docs.un.org/S/RES/1325(2000).
5. United Nations Security Council. 2004. *Statement by the President of the Security Council*. S/PRST/2004/40. United Nations Security Council. *https://www.un.org/womenwatch/ods/S-PRST-2004-40-E.pdf*.
6. United Nations Security Council. 2008. *Security Council Resolution 1820*. S/RES/1820(2008). United Nations Security Council. https://undocs.org/S/RES/1820(2008).
7. United Nations Security Council. 2009a. *Security Council Resolution 1888*. S/RES/1888(2009). United Nations Security Council. *https://www.un.org/shestandsforpeace/sites/www.un.org.shestandsforpeace/files/unscr_1888_2009.pdf*.
8. United Nations Security Council. 2009b. *Security Council Resolution 1889*. S/RES/1889(2009). United Nations Security Council. *https://undocs.org/S/RES/1889(2009)*.
9. United Nations Security Council. 2010. *Security Council Resolution 1960*. S/RES/1960(2010). United Nations Security Council. *https://undocs.org/S/RES/1960(2010)*.
10. United Nations Security Council. 2013a. *Security Council Resolution 2106*. S/RES/2106(2013). United Nations Security Council. *https://undocs.org/S/RES/2106(2013)*.
11. United Nations Security Council. 2013b. *Security Council Resolution 2122*. S/RES/2122(2013). United Nations Security Council. *https://undocs.org/S/RES/2122(2013)*.
12. United Nations Security Council. 2015. *Security Council Resolution 2242*. S/RES/2242(2015). United Nations Security Council. *https://undocs.org/S/RES/2242(2015)*.
13. United Nations Security Council. 2019a. *Security Council Resolution 2467*. S/RES/2467(2019). United Nations Security Council. *https://docs.un.org/en/S/RES/2467(2019)*.
14. United Nations Security Council. 2019b. *Security Council Resolution 2493*. S/RES/2493(2019). United Nations Security Council. *https://docs.un.org/en/S/RES/2493(2019)*.
15. Women, Peace and Security Focal Points Network (WPS Focal Points Network). n.d. Accessed March 3, 2026. *https://wpsfocalpointsnetwork.org/resources/*.